

“МОНГОЛ-ОРОСЫН 1912 ОНЫ ГЭРЭЭ БА И.Я.КОРОСТОВЕЦ” ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

Монгол-Оросын хооронд 1912 онд найрамдлын гэрээ байгуулсны 100 жилийн ой 2012 онд тохиосон бөгөөд уг ойд зориулан олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг Монгол Улсын Гадаад харилцааны яам, ОХУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, Шинжлэх Ухааны Академи, Олон улс судлалын хүрээлэн хамтран зохион байгуулав. Хурал 2012 оны 11 дүгээр сарын 2-нд ГХЯ-ны “Зөвшилцөл” танхимд болж өнгөрөв. Хуралд Монгол, ОХУ, Япон, Канад улсын эрдэмтэн судлаачид нийт 14 илтгэл тавьж, монголын болон гадаадын эрдэмтэн судлаачид, оюутан, шашны болон олон нийтийн байгууллагын төлөөлөл оролцсон. Хурлын нээлтэд УИХ гишүүн, ГХЯ-ны сайд Л.Болд, ОХУ-аас Монголд улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд В.В.Самойленко, ШУА-ийн тэргүүн дэд Ерөнхийлөгч Д.Рэгдэл, ОУСХ-ийн захирал Л.Хайсандай нар үг хэлж мэндчилгээ дэвшүүлэв. Үндсэн илтгэлийг доктор О.Батсайхан “Монгол, Оросын 1912 оны найрамдлын гэрээ ба И.Я.Коростовец” сэдвээр тавив., Хурлын онцгой зочноор Канадын Торонтогийн их сургуулийн профессор Ольга Бакич оролцож, 1912-1913 онд Монгол-Оросын хооронд гэрээг байгуулах Оросын хаант гүрний бүрэн эрхт төлөөлөгчөөр томилогдон ажиллаж байсан, Оросын нэрт дипломатч И.Я.Коростовецийн өдрийн тэмдэглэлийг хэрхэн хадгалж, хамгаалж, өвлүүлсэн талаар “И.Я. Коростовецийн өдрийн тэмдэглэлийг хадгалж ирсэн тухай” сэдвээр илтгэл тавьсан нь ихээхэн сонирхол татсан билээ. Мөн Доктор З.Лонжид “1912 оны Монгол – Оросын хэлэлцээрийн тухай эрэгцүүлэл”, доктор Тачибана Макото “1912 оны Монгол, Оросын найрамдлын гэрээ ба олон улсын эрх зүй” илтгэлүүдэд шинэ баримтуудыг дэлгэж, тухайн түүхэн үйл явцыг шинэ энцгөөс тусгасан байна.

Түүнчлэн доктор Н.Хишигтийн “Монгол цэргийг бэлтгэх тухай Монгол, Оросын гэрээ бичгүүд”, доктор Ц.Батбаярын “1912 оны Монгол, Оросын хэлэлцээр ба Юань Шикайн байр суурьтай холбоотой зарим асуудал”, профессор Кимитака Мацузатогийн “Ази маягийн Орос: геополитик ба газар нутгийн менежмент” илтгэлүүд судлаачдын сонирхлыг ихээр татсан билээ.

Энэхүү хурал дээр эрдэмтэн судлаачид урьд өмнө хэвлэгдэж байгаагүй архивын шинэ материалуудыг дэлгэн харуулж, эл түүхэн үйл явцтай холбоотой асуудлын бодит үнэнийг ил болгохын зэрэгцээ судлаачид илтгэлүүдтэй холбоотой санал шүүмж, өөр өөрийн байр сууриа илэрхийлсэнээс харахад цаашид судлах зүйл их байгаа нь харагдаж байлаа.

Мэдээ бэлтгэсэн Ж.Орхон